БАТЛАВ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ОТГОНЧИМЭГ
2024 оны ....сарын .....ны өдөр

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН 01 АЛБАН ДААЛГАВАР "БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ- ХАРИУЦЛАГАТАЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА" НЭРЭМЖИТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**2024 оны 03-р сарын 20 ны өдөр**

| д/д | ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ | ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА | ХУГАЦАА | ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН |
|---|---|---|---|---|
| **1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах чиглэлээр** | | | | |
| 1.1 | Аймаг, сумын Засаг даргыг Газрын тухай хууль тогтоомжийн хүрээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах; | -Монгол улсын Газрын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан мэдээлэл бэлтгэн танилцуулах.<br>- Сумын Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах талаар сумдын Засаг дарга, орлогч дарга, Тамгын газрын дарга нарыг хамруулсан сургалт зохион байгуулах. | 2024.04.15-2024..07.01 | ГУХ-ын дарга Э.Баярмагнай |
| 1.2 | Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг Газрын тухай хууль, журмын дагуу цахимаар зохион байгуулж, ялагчид газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэх; | -Олон нийтэд тухайн жилийн төлөвлөгөөний нэгж талбарыг олон нийтэд мэдээлэл цахим хэлбэрээр хүргэх,<br>-Сумдын Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг 100 хувь цахимаар зохион байгуулах. | 2024.04.15-2024.10.01 | Газрын удирдлагын хэлтэс |
| 1.3 | Монгол Улсын Засгийн газраас баталсан эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ, байршил, зориулалтад нийцүүлэн газрыг эзэмшүүлж, ашиглуулах; | Засгийн газрын баталсан жагсаалтын дагуу зохион байгуулалтыг хийж газрыг хууль журмын дагуу олгох | 2024.04.15-2024.10.01 | ГУХ-ын дарга Э.Баярмагнай |
| 1.4 | Иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой хүсэлтийг цахимаар хүлээн авч холбогдох хуулийн хугацаанд шийдвэрлэх; | Иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой хүсэлтийг 100 хувь цахимаар хүсэлтийг хүлээн авч 15 хоногт багтаан шийдвэрлэх. | 2024.03.22-2024.12.15 | ГУХэлтэс |
| 1.5 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хууль зүйн үндэслэл бүхий хариуг өгч эцэслэн шийдвэрлэх; | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хуулийн хүрээнд 30 хүртэлх хоногт багтаан шийдвэрлэх. | 2024.03.22-2024.12.15 | ГУХэлтэс |
| 1.6 | Газрын харилцааны салбарын ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдгээрийн нийгмийн баталгааг дэмжих, мэргэшүүлэх, ур чадварыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх; | -Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх<br>- Хууль журмын хүрээнд олгох нэмэгдэл, урамшууллыг төсөвтөө багтаан тухай бүр өгч байх<br>- Хариуцлага ёс зүйг өндөржүүлж, сургалт сурталчилгааг тогтмол кохион байгуулах | 2024.03.22-2024.12.15 | Ерөнхий нягтлан бодогч, ёс зүйн дэд хороо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.7 | Албан хаагчдын тоног төхөөрөмж, ашиглах нөхцлийг сайжруулах тал дээр орон нутгийн байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх; | -Шаардлагатай тоног төхөөрөмжийн судлгааг, тооцоолоптой гаргаж танилцуулах<br>-Удирдагуудад танилцуулж төсөвт тусгуулах талаар анхаарах | 2024.04.01-2024.12.15 | Хэлтсийн дарга нар, Мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтан |
| **2. *Санхүүгийн сахилга бат, хариуцлагыг чангатгах чиглэлээр*** | | | | |
| 2.1 | Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад журам, заавар болон тус газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өдөр тутмын үйл ажлллагаандаа мөрдөж, хуулийн хугацаанд холбогдох тайлан, мэдээг хүргүүлэн аж/1ллах; | Холбогдох хууль, журмын дагуу санхүүгийн үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлж ажиллах,хагас бүтэн жилээр тайлагнаж холбогдох газруудад хүргүүлэх. | 2024.01.01-2024.12.31 | Ерөнхий нягтлан бодогч Л.Туяа |
| 2.3 | Батлагдсан төсвийн зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй, хэмнэлттэй зарцуулах, авлага, өглөг үүсгэхгүй, санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллах; | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу сар бүр хэмнэлттэй зарцуулж, өр авлага бууруулж, шинээр үүсгэхгүй ажиллах | 2024.01.01-2024.12.31 | Ерөнхий нягтлан бодогч Л.Туяа |
| 2.4 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүжилтийг цаг тухайд нь олгох; | Худалдан авах ажиллагааг тухай бүрд нь журмын дагуу хийж санхүүгийн бүртгэлд тусгах. | 2024.01.01-2024.12.31 | Ерөнхий нягтлан бодогч Л.Туяа |
| 2.5 | Тус газрын харьяа байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн онлайн программын шинэчлэлтийг 2024 онд нэвтрүүлэх ажлыг нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлэх тул батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэж, санхүүгийн хяналтыг сайжруулах; | Батлагдсан төсвөөс нэхэмжлэхийн дагуу төлбөрийг шилжүүлэх. | 2024.01.01-2024.12.31 | Ерөнхий нягтлан бодогч Л.Туяа |
| 2.6 | Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах; | Аудитын дүгнэлтээр гарсан зөрчил дээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах. | 2024.01.01-2024.12.31 | Ерөнхий нягтлан бодогч Л.Туяа |
| **3. *Геодези, зураг зүйн чиглэлээр*** | | | | |
| 3.1 | Орон нутгийн төсвөөр хийгдэж буй газар зүйн нэрийн тодруулалтын ажил, том масштабын байр зүйн зураг, инженерийн шугам сүлжээний зураглал хийх ажлын явц, үр дүнд хяналт тавих, гарсан алдаа зөрчлийг арилгуулах; | -Сумдын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг энэ ондоо багтаан мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж хүлээн авах.<br>-Газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх<br>-Газар зүйн нэрийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн ажлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн ГЗБГЗЗГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулах. | 2024.04.01-2024.11.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |
| 3.2 | Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийж буй геодези, зураг зүйн ажилд хяналт тавих, хийгдэж байгаа ажлуудыг давхардуулан хийхгүй байхад анхаарах; | -Хяналт тавьж ажиллах<br>-Гүйцэтгэсэн ажлуудыг urban.gov.mn цахим системээр хүлээн авах ажлыг зохион байгуулах. | 2024.04.01-2024.12.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |
| **4. *Суурь судалгаа, мониторингийн чиглэлээр*** | | | | |
| 4.1 | Аймаг, нийслэлийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршил, талбайн хэмжээг улирал тутамд бүртгэн зураглаж, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх; | Аймаг хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршил, талбайн хэмжээг бүртгэж зураглах<br>-Холбогдох байгууллагуудад чиглэл өгөх<br>-тайлан мэдээллийг авч нэгтгэн танилцуулж, холбогдох арга хэмжээг | 2024.04.01-2024.11.31 | Мэргэжилтэн Б.Батчимэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тухай бүр авч ажиллах | | |
| 4.2 | Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, бэлчээрийн биомасс, даацыг тодорхойлж, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд ашиглах; | -Зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглах.<br>- Үр дүнг холбогдох байгууллагуудад танилцуулж ашиглах | 2024.04.01-2024.12.31 | Мэргэжилтэн Б.Батчимэг |
| 4.3 | Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа бэлчээрийн фото мониторингийн цэгт хээрийн судалгааны ажлыг бүрэн хийж гүйцэтгэхэд дүүрэг, сумын Засаг дарга нартай хамтран ажиллах, хээрийн судалгааны үр дүнг чанартай боловсруулж, Газрын мониторингийн цахим системд үр дүнг оруулж, бэлчээрийн газрын төлөв байдлыг тодорхойлох, бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд суурь мэдээлэл болгон ашиглаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал, малчид, олон нийтийг нээлттэй мэдээллээр хангаж ажиллах; | -Багийн ИНХ-д өмнөх жилүүдэд хийсэн ажлын үр дүнг харьцуулж танилцуулах<br>-Сумын ИТХ-д ажлын үр дүнг танилцуулж, цаашид анхаарах талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажиллах<br>- Сумын Засаг дарга нарт тухайн жилийн төлөвлөгөө боловсруулж батлуулахдаа тус ажлын үр дүнг харгалзаж байх талаар зөвлөгөө чиглэл өгөх | 2024.07.01-2024.12.31 | Мэргэжилтэн Б.Батчимэг |
| | ***5. Газар зохион байауулалтын төлөвлөлтийн чиалэлээр*** | | | |
| 5.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулж ажиллах; | -Ажлын даалгаврын дагуу хяналт тавьж ажиллах<br>-Ажлын даалгаврын дагуу шаардлагатай мэдээллийг гүйцэтгэгч байгууллагад гаргаж өгөх | 2024.04.01-2024.12.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |
| 5.2 | Аймгийн хэмжээнд эрх бүхий байгууллагаар батлагдсан болон боловсруулагдаж байгаа хот байгуулалтын баримт бичгүүдийг Газар зохион байгуулалт, хоттөлөвлөлтийн цахим системд бүртгэх, цахим системд бүртгэгдсэн хот байгуулалтын баримт бичгийн хавсралт материал, төлөвлөлтийн орон зайн зураглалын мэдээллийг бүрэн зурагласан эсэхийг нягталж байх | -Төлөвлөгөөний тодотголд хяналт тавих<br>- Баримт бичгүүдийг шаардлагын дагуу цахим системд оруулахад анхаарах | 2024.04.01-2024.12.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |
| 5.3 | Сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулах, хуулиар тогтоосон хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүсийг зөрчихгүйгээр хээрийн судалгаа, хэмжилт зураглалыг бүрэн хийж төлөвлөхөд анхаарч холбогдох мэргэжилтнүүд болон газрын даамлуудыг мэргэжил, арга зүйгээр тогтмол хангах, орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийг газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэж байгаа ажлын талаарх нээлттэй мэдээллээр хангаж ажиллах; | -Сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний тогтоолыг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулан баталгаажуулж, хяналт тавьж ажиллах<br>-Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлуулж, хориглолт хязгаарлалтын бүсийг мэдээллийн санд бүрэн оруулах<br>-Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг гүйцэтгэгч байгууллагаар газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулан дагаж мөрдөх<br>-Хорих ангийн хамгаалалтын зурвас болон бусад хориглолт хамгаалалтын зурвасыг хууль тогтоомжийн дагуу цахим системд оруулах ажлыг зохион байгуулах<br>-Сумдын газрын даамлуудад жилд 2 удаа газар зохион байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр сургалт зохион байгуулан мэргэжилт арга зүйн зөвлөгөө өгч хамтарч ажиллах<br>-Иргэд, олон нийтэд зориулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх болон газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг цахим системээс хэрхэн харах талаар гарын авлага бэлдэж тараан мэдээ, мэдээлэл өгч ажиллах | 2024.05.01-2024.12.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5.4 | Нийслэл, сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" 110 дугаар тогтоолын 2.1-т заасны дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан нэгж талбар бүрээр төлөвлөх; | -Сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд хянал тавих, арга хэмжээ болон зориулалтыг хянан шалгах, нэгж талбар бүрээр төлөвлөн оруулахад арга зүйн зөвлөгөө өгөх | 2024.04.01-2024.12.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |
| 5.5 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдээгүй сумдыг төлөвлөлтийн баримт бичигтэй болгох ажлыг зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, дүгнэлт гаргах; | -Сумдын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө гүйцэтгэгч байгууллагаас ажлын даалгаврын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулах<br>-Шаардлагатай судалгаа, мэдээллийг гаргаж өгч хамтран ажиллах | 2024.04.01-2024.12.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |
| 5.6 | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн талаар 2023 онд гарсан маргааныг орон нутагтаа шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, иргэд, олон нийтийг хилийн цэсийн талаарх үнэн бодит мэдээллээр хангаж ажиллах; | -Маргааныг орон нутагтаа шийдвэрлэн ажиллах<br>-Иргэд олон нийтэд хилийн цэсийн талаар үнэн зөв бодиттой мэдээллийг байгууллагын пэйж хуудас болон цахим хуудсаар дамжуулан мэдээллэх | 2024.04.01-2024.12.31 | Ахлах мэргэжилтэн Д.Мишээл |
| | ***6. Газрын кадастрын мэдээллийн системийн чиглэлээр*** | | | |
| 6.1 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд нэгжталбарын системийн Газрын кадастрын цахим системд нэгжталбарын цахим хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах, хувийн хэргийг холбогдох хууль, "Нэгж талбарын хувийн хэргийг хөтлөх журам"-ын дагуу үнэн зөв, гүйцэд бүрдүүлэх ажлыг зохион байгуулах; | Газрын цахим системийн мэдээллийн баазад ачаалал үүсгэж, буруу мэдээлэл үүссэх алдаа дутагдал гаргахаас сэргийлж хавсралтын үнэн зөв хавсаргаж, Цахим хувийн хэргийн бүрдэлтэд анхаарал тавьж ажиллах. | 2024.04.01-2024.12.31 | Мэргэжилтэн О.Энхзул |
| 6.2 | Газар эзэмших гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламж байгуулах, хөрсний бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байгаа байдалд дүгнэлт өгч илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах /тариалангийн талбай, уул уурхай гэх мэт/; | -Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвөлгөөнд танилцуулга бэлтгэх, танилцуулах,<br>- Олон талт арга хэмжээгээр сургалт сурталчилгааг зохион байгуулж олон нийтэд мэдээлэл хүргэж байх | 2024.04.01-2024.12.31 | Мэргэжилтэн О.Энхзул |
| 6.3 | Egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, танилцуулах арга хэмжээг зохион байгуулах, газар эзэмших, өмчлөх, ашиглах талаарх хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх; | Egazar.gov.mn үйл ажиллагааны талаар иргэдэд хандсан мэдээлэл тайлбарыг цахим сайт, пейж хаягуудад байршуулах мэдээлэл бэлтгэж ажиллах. | 2024.04.01-2024.12.31 | Мэргэжилтэн О.Энхзул |
| 6.4 | Эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж, Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нөхөн бүрдүүлэх арга хэмжээг эцэслэн дуусгах; | ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргах, нөхөн бүрдүүлэх арга хэмжээг дуусгах. | 2024.04.01-2024.05.31 | Мэргэжилтэн О.Энхзул |
| 6.5 | Газрын харилцааны цахим үйлчилгээний Киоск машиныг бүх сум, дүүрэгт байршуулан хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах; | Сумдын удирдлагуудад цахим үйлчилгээний Киоск машиныг танилцуулж 2025 оны төсөвт хөрөнгийг шийдвэрлэхээр ажиллах. | 2024.04.01-2024.05.01 | Мэргэжилтэн О.Энхзул |
| 6.6 | Газрын харилцааны цахим үйлчилгээний Киоск машинаар дамжуулан газартай холбоотой үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй үзүүлэх, үйлчилгээний хураамжийг цахим системээр төлөх боломжийг бүрдүүлэх; | Газрын харилцааны цахим үйлчилгээний Киоск машинаар дамжуулан газартай холбоотой үйлчилгээг цахимаар сурталчлах ажлыг зохион байгуулах. | 2024.04.01-2024.12.31 | Мэргэжилтэн О.Энхзул |
| | ***7. Хяналт, шалгалтын чиглэлээр*** | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7.1 | Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд эзэмшүүлэх, ашиглуулах газрыг нэгжталбар бүрээр нарийвчлан төлөвлөж зурагт оруулах, мөн ойн сан болон усны сан бүхий газрын төлөвлөлтөд анхаарч ажиллах, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгахгүй, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмыг баримтлахгүйгээр дуудлага худалдааны анхны үнээр тооцсон газрын үнийг төсөвт төвлөрүүлж газар олгодог зөрчлийг арилгах, таслан зогсоох; | - Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөлтөд улирал бүр хяналт тавих | 2024.04.01-2024.12.31 | Байцаагч Д.Ганзориг |
| 7.2 | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийх нэрийн доор тухайн жилд олгох газрын хэмжээг нэмэгдүүлж, газар олгодог зөрчлийг гаргахгүй байхад анхаарч ажиллах; | -Засгийн газрын тогтоолыг мөрдлөг болгон, зөрчил гаргахгүй байлгах | 2024.04.01-2024.12.31 | Байцаагч Д.Ганзориг |
| 7.3 | Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг хүчингүй болгоход иргэн, хуулийн этгээдэд харилцан адилгүй үйлчилж, Монгол Улсын Дээд шүүхээс Газрын тухай хуулийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор гаргасан 2008 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай" 15 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах; | -Монгол Улсын Дээд шүүхээс 2008 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай" 15 дугаар тогтоолыг аймаг, сумын хэмжээнд мөрдөж ажиллах.<br>- Хүчингүй болгох газрын судалгааг гаргаж Засаг дарга нарт чиглэл өгөх<br>- Тайланг мэдээг улирал тутам авч танилцуулах | 2024.04.01-2024.12.31 | Байцаагч Д.Ганзориг, ГУХ-ийн дарга |
| 7.4 | Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, газар эзэмших, ашиглах эрхийийг дуусгавар болгоход газар дээр нь судалгаа хийх, холбогдох баримт бичгийг хянаж үзэх, тухайн маргаан бүхий захиргааны актыг гаргахаас өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийг оролцуулан, захиргааны акт гаргахтай холбоотой сонсгох ажиллагаа явуулах, урьдчилсан байдлаар мэдэгдэж тайлбар, нотлох баримт гаргуулах, бодит нөхцөл байдлыг судлан, нягталж шалгах | - Сумдаас иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох, газар эзэмших, ашиглах эрхийг дуусгавар газрын судалгааг хариуцсан мэргэжилтэн, газрын даамлаас гаргуулан авах,<br>- Батлагдсан ажлын хэсгийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байх. | 2024.04.01-2024.12.31 | ГУХ, Байцаагч Д.Ганзориг |
| 7.5 | Газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастр, геодези, зураг зүйн чиглэлээр илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллах, хуулийн хэрэгжилтийг хангуулах; | -Илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, тухай бүр хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | 2024.04.01-2024.12.31 | Байцаагч Д.Ганзориг |
| | ***8. Мэдээллийн технологийн чиглэлээр*** | | | |
| 8.1 | Салбарын мэдээлэл дамжуулах сүлжээний хэвийн найдвартай аюулгүй ажиллагааг хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд шинээр олгосон Тэр интернэт" төхөөрөмж болон нийт мэдээлэл дамжуулах сүлжээний хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг ханган ажиллах; | - Сумдын гэр интернетүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэн шинээр солих ажлыг ОЗМТХ-тэй хамтран зохион байгуулж, салбарын хэмжээнд сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан байх. | 2024.04.01-2024.12.31 | Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Мянганбаяр |
| | ***9. Архивын баримт бүрдүүлэлтийн чиглэлээр*** | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9.1 | Архивын баримтыг хадгалах стандарт орчныг бүрдүүлэх, цахимжуулах ажлыг эрчимжүүлж, цахимжуулсан баримтыг Архивын цахим системд холбох, нэгж тагбарын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж байгууллагын архивт татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах; | - Архивын баримтыг цахимжуулах<br>- Архивын өрөө тасалгааг сайжруулах, нэмэгдүүлэхэд анхаарч холбогдох байгууллага, удирдлагуудад танилцуулж шийдвэрлүүлэх асуудлыг зохион байгуулах | 2024.05.01-2024.09.01 | Архив хариуцсан мэргэжилтэн Т.Урантогос |
| **10. Газрын бирж, үнэлгээ, төлбөрийн чиглэлээр** | | | | |
| 10.1 | Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу цахимаар зохион байгуулж, нээлттэй, ил тод байх, тэгш, шударга оролцоог хангах; | Аймгийн 2024 оны газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулах, олон нийтэд сурталчлах | 2024.05.01-2024.12.31 | Мэргэжилтэн Б.Батчимэг |
| 10.2 | Газрын төлбөр, татварын цахим системд бүртгэлтэй хүчинтэй гэрээний төслөөр газрын төлбөрийн ногдуулалтыг тухай бүр үүсгэж, Татварын удирдлагын нэгдсэн цахим системд илгээж байх; | Хүчинтэй нэгж талбарын тоогоор тухайн жилийн ногдуулалтыг үүсгэж татварын системд илгээх | 2024.02.01-2024.12.31 | Мэргэжилтэн Б.Батчимэг |
| 10.3 | Газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг тогтмол бүртгэж, Газрын үнэлгээний цахим системээр газрын масс үнэлгээг тооцох. | Худалдагч, худалдан авагчаас зах зээлийн үнийн мэдээллийг авч цахим биржид тогтмол бүртгэх. | 2024.04.01-2024.11.01 | Мэргэжилтэн Б.Батчимэг |

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНАЛ НЭГТГЭСЭН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БАЯРМАГНАЙ